

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, түүгээр үйлчлэх, хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

2 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж

2.1. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж нь энэ хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь дараахь үйл ажиллагаанд үйлчлэхгүй:

3.1.1.ашиг олох зорилгогүй, хувийн /гэр бүлийн/ хэрэгцээнд зориулан уламжлалт аргаар, байгалийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн ашиглан согтууруулах ундаа үйлдвэрлэх;

3.1.2.ашиг олон зорилгогүй, хувийн /гэр бүлийн/ хэрэгцээнд зориулан бага хэмжээгээр улсын хилээр нэвтрүүлэх;

3.1.3.Монгол Улсын болон гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Засгийн газар хоорондын олон улсын байгууллага, тэдгээртэй адилтгах бусад байгууллагын албан хэрэгцээнд зориулан согтууруулах ундааг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;

3.1.4.Олон улсын чанартай үзэсгэлэн, худалдаанд оролцох, бүтээгдэхүүний дээж, загварыг танилцуулах, Монгол Улсын болон гадаад улсын эрх

бүхий байгууллагад шинжлүүлэх, импортлох, экспортлох зөвшөөрөл авах зорилгоор Монгол Улсын хилээр нэвтрүүлэх.

3.2.Энэ хуулийн 3.1.2, 3.1.3, 3.1.4-т заасан бүтээгдэхүүний нэр төрөл, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх хэмжээг согтууруулах ундааны сав, баглаа, боодол, нэвтрүүлж байгаа этгээдийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэлд үндэслэн Засгийн газар тогтооно.

4 дүгээр зүйл.Согтууруулах ундаа, түүний эргэлт

4.1.Хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт, бүх төрлийн архи, 2 хувиас дээш этилийн спирт агуулсан шарз, дарс, тэдгээрийн үндсэн дээр бэлтгэсэн аливаа ундаа, шар айраг, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи согтууруулах ундаанд хамаарна.

4.2.Согтууруулах ундааг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа нь согтууруулах ундааны эргэлтэд хамаарна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ

5 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтийг төрөөс зохицуулах

5.1.Төрөөс согтууруулах ундааны эргэлтийг доор дурдсан хэлбэрээр зохицуулна:

5.1.1.согтууруулах ундааны эргэлтийн эрх зүйн орчныг бүрдүүлэх;

5.1.2.согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих;

5.1.3.согтууруулах ундааны эргэлтэд ногдуулах татвар, хураамжийн төрөл, хэмжээг тогтоох;

5.1.4.согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журмыг тогтоох, согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

5.1.5.согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын стандартыг тогтоож, мөрдүүлэх;

5.1.6.согтууруулах ундаа хэрэглэгчийн эрх ашиг, эрүүл мэндийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах, хүрээлэн байгаа орчныг хамгаалах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

5.1.7.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх журам, байршил, өдөр, цагийн хязгаарлалтыг тогтоох;

5.1.8.согтууруулах ундааны үйлдвэрлэл, хэрэглээ, түүний хор хөнөөлийн талаар үндэсний хэмжээний судалгаа, хяналт, шинжилгээ хийх;

5.1.9.согтууруулах ундааны хэрэглээг багасгах, зохистой хэрэглээний стандарт бий болгох, түүний хор хөнөөлийг сурталчилан таниулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

5.1.10.хууль тогтоомжид заасан бусад.

6 дугаар зүйл.Нутгийн захиргааны байгууллагаас согтууруулах ундааны эргэлтийг зохицуулах

6.1.Нутгийн захиргааны байгууллага тухайн нутаг дэвсгэр дэх согтууруулах ундааны эргэлтийг доор дурдсан хэлбэрээр зохицуулна:

6.1.1.хууль тогтоомжид заасан журмын дагуу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

6.1.2.тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаанд хяналт тавих;

6.1.3.тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх энэ хуульд заасан цагийн хязгаарыг нэмж тогтоох;

6.1.4.хууль тогтоомжид заасан бусад.

ГУРАВДУГААР БҮЛЭГ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ

7 дугаар зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрөл

7.1.Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын төв байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн Засгийн газар олгож, хүчингүй болгоно. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн хяналтын төв байгууллагын саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, дуусгавар болгоно.

7.2.Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг тухайн нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга олгож, сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.

7.3.Энэ хуулийн 7.1, 7.2-д заасан тусгай зөвшөөрлийг төсөл сонгон шалгаруулах журмын үндсэн дээр олгоно. Төсөл сонгон шалгаруулах болон үйлдвэрлэлд хяналт тавих журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

7.4.Энэ хуулийн 7.1, 7.2-д заасан тусгай зөвшөөрөлд согтууруулах ундааны нэр төрөл, үйлдвэрлэх арга хэрэгсэл, түүхий эд, үйлдвэрийн байршил болон хүчин чадал, нэг жилд үйлдвэрлэх согтууруулах ундааны дээд хэмжээг заана.

7.5.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглох бөгөөд үйлдвэрлэх согтууруулах ундааны нэр, төрөл, үйлдвэрийн байршлыг өөрчлөх, эсхүл шинэ нэр, төрлийн согтууруулах ундаа үйлдвэрлэхэд энэ хуулийн 7.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулна.

7.6.Энэ хуулийн 7.4-т заасан үйлдвэрлэлийн хүчин чадлыг тооцоолох журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

8 дугаар зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага

8.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүсэгч дараахь шаардлагыг хангасан байна:

8.1.1.ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан өөрийн өмчлөлийн үйлдвэрлэлийн болон агуулахын байртай байх;

8.1.2.өөрийн өмчлөлийн, чанар, аюулгүй байдлын стандарт, шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжтэй байх;

8.1.3.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хатуулгыг бүртгэх, мэдээлэх тоног төхөөрөмж суурилуулах, түүнийг нэгдсэн сүлжээнд холбох техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх;

8.1.4.мэргэжлийн боловсон хүчинтэй байх;

8.1.5.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг шалган тогтоох лабораторитой байх;

8.1.6.хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч нь урьд өмнө архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчиж, шийтгүүлж байгаагүй байх;

8.1.7.хугацаа хэтэрсэн татварын болон бусад өр, төлбөргүй байх.

9 дүгээр зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

9.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгана.

9.2.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.3, 6.4-т заасан журмыг баримтална.

10 дугаар зүйл. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

10.1.Энэ хуулийн 7.1, 7.2-д заасан тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

10.1.1.согтууруулах ундааны үйлдвэрийн төслийн баримт бичиг;

10.1.2.аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;

10.1.3.үйлдвэрийн байр болон бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хянах шалгах лабораторийн талаарх мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт;

10.1.4.үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, тэдгээрийн чанар, стандарт, өмчлөлийн талаархи мэдээлэл;

10.1.5.үйлдвэрлэх согтууруулах ундааны нэр, төрөл, хэмжээ, үйлдвэрлэлийн хүчин чадлыг тодорхойлсон баримт бичиг;

10.1.6.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хатуулгыг бүртгэх, мэдээлэх тоног төхөөрөмж суурилуулах, түүнийг нэгдсэн сүлжээнд холбох тооцоолол;

10.1.7.татварын албанд бүртгүүлсэн тодорхойлолт, тоо хэмжээ, хатуулгыг бүртгэх, мэдээлэх тоног төхөөрөмжийн талаархи санал, дүгнэлт;

11 дугаар зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

11.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг дараахь тохиолдолд түдгэлзүүлнэ:

11.1.1.илэрсэн зөрчлийг арилгах, үйл ажиллагаагаа хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэх талаар хяналт тавих эрх бүхий байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй;

11.1.2.хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтад заасан согтууруулах ундаа үйлдвэрлэх шаардлагыг хангахгүй болсон, эсхүл энэ тухай хангалттай үндэслэл байгаа;

11.1.3.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хатуулагт хяналт тавих, бүртгэх боломжгүй болсон;

11.1.4.архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд сайн дураараа биелүүлээгүй;

11.1.5.татварын тухай хууль тогтоомж зөрчсөн, онцгой албан татварын тэмдэгт ашиглах журам зөрчсөн талаар татварын байгуулагын мэдэгдэл ирсэн;

11.1.6.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зөрчил гаргасан.

11.2.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 11.1-д заасан зөрчлийг арилгах хүртэл, үндэслэл бүхий хугацаагаар түдгэлзүүлэх бөгөөд түдгэлзүүлэх үндэслэл арилгасан тохиолдолд сэргээнэ.

11.3.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 11.2-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй. Тийнхүү гомдол гаргасан нь энэ хуулийн 11.2-т заасан шийдвэрийг түдгэлзүүлэх, эсхүл биелүүлэхийг хойшлуулах үндэслэл болохгүй.

11.4.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх хүртэл тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

12 дугаар зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох, хүчингүй болгох

12.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлд заасан хугацаа дууссан, тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасан бол тусгай зөвшөөрлийг дуусгавар болгоно.

12.2.Дараахь тохиолдолд согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

12.2.1.энэ хуулийн 10.1-д заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл тэдгээр нь худал мэдээлэл агуулсан болох нь сүүлд тогтоогдсон;

12.2.2.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх эрхгүй этгээдэд согтууруулах ундаа нийлүүлсэн, худалдсан;

12.2.3.энэ хуулийн 45.2-т заасан онцгой албан татварын тэмдэггүй согтууруулах ундаа нийлүүлсэн, худалдсан, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдсэн;

12.2.4.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг биелүүлээгүй буюу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд согтууруулах ундаа үйлдвэрлэсэн;

12.2.5.нэг жилийн хугацаанд хоёр, түүнээс удаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээний талаар худал мэдээлэл ирүүлсэн, эсхүл уул мэдээллийг хугацаанд нь ирүүлээгүй;

12.2.6.стандарт, техникийн зохицуулалтад нийцээгүй согтууруулах ундаа үйлдвэрлэсэн;

12.2.7.нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нэг зөрчлийг давтан гаргасан;

12.2.8.хяналт тавих эрх бүхий байгууллагаас үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, тэдгээрийн тоо хэмжээ, чанар, аюулгүй байдал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хатуулгыг бүртгэх, мэдээлэх тоног төхөөрөмжид хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан;

12.2.9.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хатуулгыг бүртгэх, мэдээлэх тоног төхөөрөмжийн ажиллагааг санаатайгаар сарниулсан, устгасан, гэмтээсэн, эсхүл лацийг хөдөлгөсөн;

12.2.10.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хугацаанд зөрчлийг арилгаагүй;

12.2.11.үйлдвэрлэлийн хүчин чадлын тогтоосон доод хувийг ашиглаагүй;

12.2.12.хүлээн авсан онцгой албан татварын тэмдгийг бусдад дамжуулсан.

13 дугаар зүйл.Согтууруулах ундааны үйлдвэрлэлд тавигдах шаардлага

13.1.Хүнсний зориулалтын бус түүхий эдээр болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр согтууруулах ундаа үйлдвэрлэхийг хориглоно.

13.2.Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг шугамын оролт, гаралтыг тоолууржуулсан зориулалтын төхөөрөмжөөр, технологийн горим, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд батлагдсан стандартын дагуу явуулна.

13.3.Согтууруулах ундааны үйлдвэрлэлд ашиглах үндсэн техник, тоног төхөөрөмж нь Монгол Улсын стандарт, техникийн шаардлагад нийцсэн байна.

13.4.Согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг тоо, хэмжээ, хатуулгыг бүртгэж, төрийн холбогдох байгууллагад тогтмол мэдээллэх үүрэгтэй.

13.5.Энэ хуулийн 13.4-т заасан тоног төхөөрөмж нь татварын байгууллагын болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн сүлжээнд холбогдсон байх бөгөөд уул тоног төхөөрөмжид тавигдах шаардлага, нэгдсэн сүлжээнд холбох журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

14 дүгээр зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэл эрхлэхийг хориглох газар

14.1.Дараахь газарт согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэхийг хориглоно:

14.1.1.төрийн байгууллагын эзэмшлийн болон үйл ажиллагаа явуулж байгаа албан байр, барилга байгууламж;

14.1.2.хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, сувилал, соёл, сувиллын газар, тэдгээрийн эзэмшил, ашиглалтад байгаа бүх төрлийн барилга, байгууламж;

14.1.3.спортын бэлтгэл, сургуулилт, уралдаан тэмцээн зохион байгуулах зориулалт бүхий бүх төрлийн барилга, байгууламж;

14.1.4.оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байр;

14.1.5.нийтийн зориулалттай орон сууцны орц, хонгил;

14.1.6.галт тэрэг, авто тээвэр, усан болон нисэх онгоцны буудал.

15 дугаар зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх доод хэмжээ

15.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай эзэмшигч тусгай зөвшөөрөлд заасан үйлдвэрлэлийн хүчин чадлын тодорхой хувиас доошгүй бүтээгдэхүүнийг заавал үйлдвэрлэнэ.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан үйлдвэрлэвэл зохих бүтээгдэхүүний доод хэмжээг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

15.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 15.1-д заасан шаардлагыг биелүүлэх боломжгүй тохиолдолд үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа түр зогсоох тухай мэдэгдлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

15.4.Тусгай зөвшөөрөл үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа сэргээх бол энэ тухай мэдэгдлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх

бөгөөд энэ хуулийн 15.1-д заасан хэмжээг тооцоолоход үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоосон хугацааг хасаж тооцно.

15.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 15.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

15.6.Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр зогсоох үндэслэл, журам болон энэ хуулийн 15.3, 15.4-т заасан мэдэгдлийг хүргүүлэх, бүртгэх журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

16 дугаар зүйл.Согтууруулах ундааны шошго, савалгаанд тавигдах шаардлага

16.1.Монгол Улсад үйлдвэрлэсэн согтууруулах ундаа нь дараахь шаардлагыг хангасан шошготой байна:

16.1.1.согтууруулах ундааны нэр, төрөл;

16.1.2.согтууруулах ундаа үйлдвэрлэгчийн нэр, хаяг;

16.1.3.согтууруулах ундааг үйлдвэрлэсэн улс;

16.1.4.шаардлагыг нь хангасан байвал зохих стандарт, техникийн зохицуулалт;

16.1.5.согтууруулах ундааны савалгааны хэмжээ;

16.1.6.орц, найрлага;

16.1.7.үйлдвэрлэсэн болон хугацаа нь дуусах он, сар, өдөр;

16.1.8.согтууруулах ундаан дахь этилийн спиртийн агууламж;

16.1.9.согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсний улмаас үүсэх хор хөнөөлийн тухай сэрэмжлүүлэг.

16.2.Гадаад улсад экспортлохоос бусад согтууруулах ундааны шошго нь монгол хэл дээр байх бөгөөд согтууруулах ундааг гадаад улсад экспортлох тохиолдолд энэ хуулийн 16.1-д заасныг мөрдөхгүй байж болно.

16.2.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь согтууруулах ундааны нэр, савлалтын хэмжээ болон тэдгээрийн өөрчлөлтийг тухай бүр татварын байгууллага болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

16.3.Гадаад улсад экспортлохоос бусад тохиолдолд согтууруулах ундааг 0,33 литрээс бага, 1,5 литрээс их хэмжээгээр савлахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ

17 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл

17.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн энэ хуулийн 17.1-д заасан нормативт нийцүүлэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал олгох бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрлийг сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, дуусгавар болгож, хүчингүй болгоно.

17.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журмыг Засгийн газар батална.

17.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хоёр жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгана.

17.4.Худалдаа үйлчилгээнд улсын техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангасан, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулсан, тохирлын гэрчилгээ авсан согтууруулах ундааг нийлүүлнэ. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.3, 6.4-т заасан журмыг баримтална.

17.5.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгоно. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч уул зөвшөөрлийг бусдад шилжүүлэх болон энэ хуульд зааснаас бусад тохиолдолд үйл ажиллагаа явуулах байршлыг өөрчлөхийг хориглоно.

17.6.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний хараат болон охин компани нь согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшихийг хориглоно.

17.7.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, түүний төрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

18 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн төрөл

18.1.Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл нь дараахь төрөлтэй байна:

18.1.1.12 хүртэл хувийн этилийн спирт бүхий согтууруулах ундаа худалдах;

18.1.2.12, түүнээс дээш хувийн этилийн спирт бүхий согтууруулах ундаа худалдах.

18.2.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл нь дараахь төрөлтэй байна:

- 18.2.1.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх;
- 18.2.2.04 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх.

18.3.Энэ хуулийн 18.2.1-д заасан тусгай зөвшөөрлийг нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдэд, 18.2.2-д заасан тусгай зөвшөөрлийг баар, диско клубын үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдэд олгоно.

18.4.Энэ хуулийн 18.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааны төрөл, түүнийг тогтоох журам болон тавигдах шаардлагыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батлана.

19 дүгээр зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох, түдгэлзүүлэх, сэргээх

19.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлд заасан хугацаа дууссан, тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасан бол тусгай зөвшөөрлийг дуусгавар болгоно.

19.2.Дараахь тохиолдолд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

19.2.1.илэрсэн зөрчлийг арилгах, үйл ажиллагаагаа хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэх талаар хяналт тавих эрх бүхий байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй;

19.2.2.хууль тогтоомж, стандартад заасан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хангахгүй болсон;

19.2.3.архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд сайн дураараа биелүүлээгүй;

19.2.4.энэ хуулийн 28.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй;

19.2.5.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зөрчил гаргасан.

19.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 19.2-т заасан зөрчлийг арилгах хүртэл гурван сараас илүүгүй хугацаагаар түдгэлзүүлэх бөгөөд түдгэлзүүлэх үндэслэл арилмагц тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

19.4.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 19.3-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Тийнхүү гомдол гаргасан нь энэ хуулийн 19.3-т заасан шийдвэрийг түдгэлзүүлэх, эсхүл биелүүлэхийг хойшлуулах үндэслэл болохгүй.

19.5.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд тухайн зөрчлийг арилгах үндэслэлтэй гэж үзвэл дахин гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

20 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

20.1.Дараахь тохиолдолд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

20.1.1.тусгай зөвшөөрөл хүссэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл тэдгээр нь худал мэдээлэл агуулсан болох нь сүүлд тогтоогдсон;

20.1.2.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх хуульд заасан өдөр, цагийн хязгаарыг хоёр сард 2, түүнээс удаа гаргасан;

20.1.3.энэ хуулийн 19.5-д заасан хугацаанд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл болсон зөрчлийг арилгаагүй, эсхүл хоёр сарын хугацаанд 2, түүнээс дээш удаа тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх зөрчил гаргасан;

20.1.4.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг биелүүлээгүй буюу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн;

20.2.5.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, хуульд зааснаас бусад тохиолдолд үйл ажиллагаа явуулах байршлыг өөрчилсөн;

20.2.6.энэ хуулийн 22.1-д заасан шийдвэрийг биелүүлээгүй;

20.2.7.энэ хуулийн 24.1, 27.3, 29.1-д заасан зөрчлийг гурван сарын хугацаанд давтан гаргасан;

20.2.8.энэ хуулийн 32.1-д заасныг зөрчсөн;

20.2.9.зургаан сар, түүнээс дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй.

21 дүгээр зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх түр зөвшөөрөл олгох

21.1.Олон нийтийг хамарсан хурим найр, ёслолын арга хэмжээ, концерт, урлагын тоглолт, олон улсын чанартай тэмцээн, уралдааныг зохион байгуулах, түүнийг дамжуулан нэвтрүүлэх газарт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх түр зөвшөөрөл олгож болно.

21.2.Энэ хуулийн 21.2-т заасан түр зөвшөөрлийг энэ хуулийн 17.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдэд олгоно.

21.3.Түр зөвшөөрлийн хугацаа нь 3 хоног, түүнээс илүүгүй байх бөгөөд энэ хуулийн 26.1-д заасан цагийн хязгаарт нийцсэн байна.

22 дугаар зүйл.Согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох

22.1.Шаардлагатай тохиолдолд тодорхой нэр, төрлийн, эсхүл бүх нэр, төрлийн согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээг тодорхой нутаг дэвсгэрт хориглох шийдвэрийг тухайн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын хэмжээнд хориглох шийдвэрийг Засгийн газар гаргана.

23 дугаар зүйл. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох газар

23.1.Дараахь газарт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно:

23.1.1.энэ хуулийн 14.1.1-д заасан газар, тэдгээрийн гаднах орчин;

23.1.2.бүх төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл /агаарын хөлөг, зорчигч тээврийн галт тэрэгний зөвшөөрөгдсөн цэгээс бусад/;

23.1.3.гудамж, талбай, цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбай, шатахуун түгээгүүрийн станц, шашны байгууллагын байр;

23.1.4.галт тэрэг, авто тээвэр, усан болон нисэх онгоцны буудлын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар;

23.1.5.олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан, спортын арга хэмжээ, тэмцээн уралдаан зохион байгуулагдаж байгаа газар, түүний ойр орчим;

23.1.6.төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн ажлын байрын дотоод орчин;

23.1.7.зориудаар тохижуулснаас бусад орон сууц, түүний суурийн давхар;

23.1.8.худалдаа, үйлчилгээний газар, олон нийтийн бусад газрын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт.

23.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд энэ хуулийн 23.1-д заасан нөхцөл шинээр бий болсон нь олгогдсон тусгай зөвшөөрөлд заасны дагуу үйл ажиллагаа явуулахад саад болохгүй.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан тусгай зөвшөөрлийн хугацааг энэ хуулийн 23.1-д заасан нөхцөл шинээр бий болсноос хойш 2-оос илүү удаа сунгахгүй.

24 дүгээр зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хориглох зүйл

24.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд дараахь зүйлийг хориглоно:

24.1.1.согтууруулах ундаа тээвэрлэх, хадгалах, борлуулах, худалдах, түүгээр үйлчлэх ажилд 18 нас хүрээгүй хүн ажиллуулах;

24.1.2.21 нас хүрээгүй, эсхүл согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;

24.1.3.стандартын шаардлагад хангаагүй, эсхүл хангасан тухай баталгаажуулалтгүй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;

24.1.4.онцгой албан татварын тэмдэггүй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;

24.1.5.согтууруулах ундааг зайнаас /холбоо, мэдээллийн сүлжээ ашиглан/ болон өөртөө үйлчлэх автомат төхөөрөмж ашиглан худалдах, түүгээр үйлчлэх;

24.1.6.согтууруулах ундааг гэрийн хаягаар хүргэх;

24.1.7.энэ хуулийн 16.3-т заасанд нийцээгүй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх.

Тайлбар: -Энэ хуульд заасан “согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх” гэж гаднах байдал, үйл хөдлөл, үг хэллэг, биеэ авч яваа байдал, хэрэглэсэн согтууруулах ундааны төрөл, хэмжээ зэрэгт үндэслэн согтууруулах ундааг үргэлжлүүлэн хэрэглэсэн тохиолдолд тухайн хүн өөрийн үйлдлийг удирдах жолоодох чадваргүй болно гэх итгэл, үнэмшлийг хэлнэ.

25 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох өдөр

25.1.Дараахь өдрүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно:

25.1.1.сар бүрийн эхний /нэгний/ өдөр;

25.1.2.долоо хоног бүрийн ням гараг;

25.1.3.цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1;

25.1.4.эрүүл мэндийг хамгаалах өдөр: 4 дүгээр сарын 7;

25.1.5.гэр бүлийн өдөр: 5 дугаар сарын 15;
25.1.6.хүүхдийн баяр: 6 дугаар сарын 1;
25.1.7.залуучуудын өдөр: 8 дугаар сарын 25;
25.1.8.Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр;
25.1.9.Их эзэн чингис хааны өдөр: Их Эзэн Чингис хааны мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1;

25.1.10.оюутан, сурагчдийн хичээлийн жилийн нээлт, хаалт, хонхны баярын өдрүүд;

25.1.11.Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр: 11 дүгээр сарын 26.

25.2.Энэ хуулийн 25.1.10-т заасан өдрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

26 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарлалт

26.1.Хуульд өөрөөр заагаагүй бол 00-09 цагийн хооронд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.

26.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах цагийн хязгаар нь энэ хуулийн 18.2, 26.1-д нийцсэн байна.

26.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаар болон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цаг, өдрийн хязгаарыг энэ хуулийн 25.1, 26.1-д заасан дээр нэмж тогтоож болно.

27 дугаар зүйл.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах тусгай шаардлага

27.1.Согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл эзэмшигч нь үйлчлүүлэгчид зориулсан худалдан авсан согтууруулах ундааг хэрэглэх танхимтай байна.

27.2.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс худалдан авсан согтууруулах ундааг энэ хуулийн 27.1-д заасан танхим хэрэглэнэ.

27.3.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 35 хувиас дээш этилийн спирт агуулсан согтууруулах ундааг үйлдвэрийн шил, савалгаатай нь худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.

27.4.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний танхимдаа халуун, хүйтэн зуушаар үйлчилдэг байна.

27.5.Согтууруулах ундаагаар үйлчлэх үйлчилгээний стандартыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

28 дугаар зүйл.Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээ

28.1.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн согтууруулах ундааг борлуулах, түүгээр бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамрагдсан байна.

28.2.Согтууруулах ундааны хариулагатай үйлчилгээний сургалт нь архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг таниулах, үйлчлүүлэгчийн насыг тогтоох, үйлчлүүлэгч согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээний арга барилыг төлөвшүүлэхэд оршино.

28.3.Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтыг аймаг, нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд гүйцэтгэх бөгөөд төлбөрийн жишгийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. Сургалтын үргэлжлэх нийт хугацаа нь 5 цагаас ихгүй, 3 цагаас багагүй байна.

29 дүгээр зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийн өмнө бичиг баримтыг шалгах

29.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан нь үйлчлүүлэгчийн хувийн бичиг баримтыг шалгах эрхтэй.

29.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан нь үйлчлүүлэгч 35 насанд хүрээгүй гэх үндэслэл байгаа тохиолдолд согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэхийн өмнө хуулиар зөвшөөрөгдсөн насанд хүрсэн эсэхийг шалгах зорилгоор үйлчлүүлэгчийн бичиг баримтыг заавал шалгана.

29.3.Энэ хуулийн 29.1-д заасан үйлчлүүлэгч бичиг баримтгүй, эсхүл хувийн бичиг баримтаа шалгуулахаас татгалзсан тохиолдолд түүнд согтууруулах ундаа худалдах, эсхүл түүгээр үйлчлэхийг хориглоно.

29.4.Энэ хуулийн 29.1-д заасан үйлчлүүлэгчийн бичиг баримтын жагсаалтыг хууль зүйн болон хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

30 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хариуцлага

30.1.21 насанд хүрээгүй, эсхүл согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсний улмаас бусдад учруулсан гэм хорыг согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

ТАВДУГААР БҮЛЭГ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

31 дүгээр зүйл. Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох

31.1. Доор дурдсан хүнд согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно:

- 31.1.1. тээврийн хэрэгсэл жолоодож байгаа;
- 31.1.2. 21 нас хүрээгүй;
- 31.1.3. жирэмсэн.

31.2. Энэ хуулийн 23.1-д заасан газарт согтууруулах ундаа хэрэглэх, ил задгай хадгалах, үйлдвэрийн савалгаа, баглаа, боодлыг задалсан байдалтай биедээ авч явахыг хориглоно.

31.3. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, бусдыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардахыг хориглоно. Бусдыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардаж согтоосны улмаас бусдад учруулсан гэм хорыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардсан этгээд хариуцна.

32 дугаар зүйл. Согтууруулах ундаа хэрэглэх боломж олгохыг хориглох

32.1.21 нас хүрээгүй хүнд согтууруулах ундаа хэрэглэх боломж олгох, хэрэглэхийг санаачлан зохион байгуулах, энэ зорилгоор орон байр ашиглуулах, мөнгөн туслалцаа үзүүлэх, согтууруулах ундааг дамжуулан өгөх, дайлах, бэлэглэх болон бусад хэлбэрээр согтууруулах ундаа олж авах, хэрэглэхэд нь туслахыг хориглоно.

32.2. Хуульд заасны дагуу хяналт шалгалтын арга хэмжээ явуулж байгаагаас бусад тохиолдолд 21 нас хүрээгүй хүн согтууруулах ундаа худалдаж авах, биедээ авч явахыг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ИМПОРТ, ЭКСПОРТ

33 дугаар зүйл. Согтууруулах ундаа импортлох, экспортлох

33.1. Согтууруулах ундаа импортлох, экспортлох үйл ажиллагаанд энэ хууль болон гаалийн тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

33.2.Гадаад улсаас импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг тогтоосон техникийн зохицуулалтын баримт бичгийг худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

33.3.Энэ хуулийн 33.1-д заасан согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлт нь согтууруулах ундаанд тавигдах үндэсний стандарт, чанар, аюулгүй байдлын үзүүлэлтээс доошгүй байна.

33.4.Импортлох болох согтууруулах ундааны жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг импортлохдоо дээжийг нь стандартчилал, эрүүл ахуйн мэргэжлийн хяналтын байгууллагаар урьдчилан шинжлүүлж, хилийн болон гаалийн эрүүл ахуйн хяналт шалгалт хийлгүүлэн баталгаажуулсан байна.

33.5.Импортлох болох согтууруулах ундааны жагсаалтыг батлахдаа согтууруулах ундааны нэр, төрөл, олон улсын стандарт, дээд ангиллын зэрэг, хатуулгийг тодорхой заана.

33.6.Согтууруулах ундаа импортлох, экспортлох журам болон тэдгээрийн чанар, аюулгүй байдалд хяналт тавих, импортлох зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална.

33.7.Импортлох болох согтууруулах ундааны жагсаалтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

33.8.Согтууруулах ундаа импортлох зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд нэг жилд импортлох согтууруулах ундааны нэр, төрөл бүрийн хэмжээ нь өмнөх жилд Монгол Улсад үйлдвэрлэсэн тухайн нэр, төрлийн согтууруулах ундааны 30 хувьтай тэнцэх хэмжээнээс илүүгүй байна.

33.9.Импортлох болох согтууруулах ундааны жагсаалтад ороогүй согтууруулах ундааг улсын хилээр оруулах, худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.

33.10.Согтууруулах ундааг импортлохдоо гаалийн төв байгууллагаас тогтоосон боомтоор улсын хилээр нэвтрүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ

34 дүгээр зүйл.Согтууруулах ундааны маркетингийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох

34.1.Согтууруулах ундаатай холбоотой дараахь үйл ажиллагааг хориглоно:

34.1.1.аливаа спортын арга хэмжээг ивээн тэтгэх, тэдгээрийг согтууруулах ундааны нэрээр нэрлэх, спортын болон соёл урлагийн арга хэмжээ,

нэвтрүүлгийн үеэр /дундуур/ согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах, байршуулах;

34.1.2.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хямдрал, урамшуулал зарлах, хөнгөлттэй үнэ, нөхцөлөөр худалдах, үйлчлэх;

34.1.3.согтууруулах ундааг бусдад үнэ төлбөргүй өгөх, санал болгох, дээж, загвар хэлбэрээр бусдыг дайлах, амталгаа зохион байгуулах;

34.1.4.тодорхой өдөр, эсхүл цагт согтууруулах ундааны үнийг бууруулах, хямдралтай үнээр худалдах, үйлчлэх;

34.1.5.нэг ижил үнээр хязгааргүй хэмжээгээр согтууруулах ундаагаар үйлчлэх;

34.1.6.хэмжээ, этилийн спиртын агууламжийн хувьд харилцан адилгүй согтууруулах ундааг адил үнээр худалдах, түүгээр үйлчлэх;

34.1.7.согтууруулах ундааг зээлээр худалдах, түүгээр зээлээр үйлчлэх;

34.1.8.согтууруулах ундаагаар шагнаж урамшуулах, цалин хөлсийг орлуулан олгох.

34.2.Төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулахаас бусад тохиолдолд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно.

35 дугаар зүйл. Архидан согтуурахын эсрэг сурталчилгаа

35.1.Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.

35.2.Согтууруулах ундаа сурталчлахыг хориглоно.

35.3.Согтууруулах ундааг сурталчлахтай холбоотой дараахь үйлдлийг хориглоно:

35.3.1.согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, лого, барааны тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, интернэт, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар гаргах;

35.3.2.21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа хэрэглэхийг зааж сургах;

35.3.3.согтууруулах ундаа үйлдвэрлэгч нь өөрийн хуулийн этгээдийн нэртэй ижил нэрээр нэрлэсэн согтууруулах ундаа үйлдвэрлэх, согтууруулах ундааны нэрээр хуулийн этгээдийг нэрлэх;

35.3.4.согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, экспорт эрхэлдэг, согтууруулах ундаа борлуулдаг хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүнийг сурталчлах, нэрийг нь олонд таниулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор соёл, урлаг, спортын болон бусад олон нийтийн арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх;

35.3.5.эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэх;

35.3.6.согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээний талаар төрөл бүрийн сугалаа, хонжвор, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа явуулах;

35.3.7.гадна хэлбэрээрээ согтууруулах ундааны сав, баглаа, боодолтой ижил төстэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах;

35.3.8.согтууруулах ундааны зар сурталчилгааг явуулах.

35.4.Согтууруулах ундааны зар сурталчилгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

35.5.Хүн, хуулийн этгээд согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг сурталчилгааг ивээн тэтгэж болно.

36 дугаар зүйл. Стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааг нийтэд мэдээлэх

36.1.Эрх бүхий байгууллагын шалгалт, шинжилгээгээр хүний амь нас, эрүүл мэндэд хортой болох нь тогтоогдсон, стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны хор хөнөөлийн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд шуурхай зарлан мэдэгдэнэ.

36.2.Стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны хор хөнөөлийн талаархи мэдээллийг бүх төрлийн хэвлэл мэдээллийн байгууллага саадгүй хүлээн авч, нийтэд түгээх үүрэгтэй.

37 дугаар зүйл. Албадан эрүүлжүүлэх

37.1.Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх ажиллагааг хуулиар зохицуулна.

38 дугаар зүйл. Эмчилгээ

38.1.Архинд донтох өвчтэй болсон этгээд өөрийн санаачилгаар эмнэлгийн байгууллагад хандаж сайн дурын үндсэн дээр эмчлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд түүнд ердийн журмаар эмчилгээ үйлчилгээ үзүүлнэ.

38.2.Архинд донтох өвчтэй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг Согтуурах, мансуурах донтой өвчтэй хүмүүсийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулиар зохицуулна.

39 дүгээр зүйл.Архидан согтуурахтай тэмцэх олон нийтийн үүсгэл, санаачилгыг дэмжих

39.1.Архидан согтуурахтай тэмцэх зорилго бүхий олон нийтийн үүсгэл санаачилгыг төрийн болон төрийн бус байгууллага дэмжин туслах үүрэгтэй.

39.2.Бүх нийтийн ерөнхий боловсролын агуулгад согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг эзэмшвэл зохих мэдлэгийг заавал тусгана.

39.3.Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ архидан согтуурч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч, ажилтнууддаа архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах үүрэгтэй.

39.4.Архидан согтуурахтай тэмцэх, согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг төрийн бодлогоор дэмжинэ.

40 дүгээр зүйл. Хураагдсан спирт, согтууруулах ундаанд шинжилгээ хийх, түүнийг борлуулах, устгах

40.1.Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан гэмт хэрэг, зөрчлийн улмаас цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, гааль болон мэргэжлийн хяналтын байгууллага, татварын албаны эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураагдсан буюу шүүхийн шийдвэрээр хураахаар эцэслэн шийдвэрлэгдсэн согтууруулах ундааг улсын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийж, дараахь дүгнэлтийн аль нэгийг гаргана:

40.1.1.эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, стандартын шаардлага хангасан тул хүнсэнд хэрэглэж болох;

40.1.2.техникийн болон хүнсний бус бусад зориулалтаар ашиглах;
40.1.3.энэ хуулийн 40.1.1, 40.1.2-т заасан зориулалтаар ашиглах шаардлага хангахгүй.

40.2.Согтууруулах ундааг хураах, шинжилгээ хийх, улсын орлого болгож борлуулах журмыг Засгийн газар батална.

40.3.Энэ хуулийн 40.1.3-д заасан согтууруулах ундааг устгах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон Улсын ерөнхий прокурор хамтран батална.

41 дүгээр зүйл.Архидан согтуурахтай тэмцэх сан

41.1.Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Архидан согтуурахтай тэмцэх сан /цаашид “сан” гэх/-г байгуулна.

41.2.Сангийн хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

41.2.1.архидан согтуурахтай тэмцэх ажлыг дэмжиж иргэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын болон гадаадын байгууллага, иргэд, харьяалалгүй хүнээс үзүүлсэн хандив, тусламжийн хөрөнгө;

41.2.2.Монгол Улсын хууль тогтоомжид үл харшлах бусад орлого.

41.3.Сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Монгол Улсын Засгийн газар батална.

41.4.Сангийн үйл ажиллагаанд шаардлагатай үед төрөөс дэмжлэг үзүүлж болно.

41.5.Архидан согтуурахтай тэмцэх ажлыг дэмжиж иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын болон гадаадын байгууллага, иргэд, харьяалалгүй хүмүүсээс үзүүлсэн хандив, тусламжийн хөрөнгө, бусад орлогыг сангийн дансанд бүртгэнэ.

41.6.Сангийн хөрөнгийг сангийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн дараахь зориулалтаар зарцуулна:

41.6.1.архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар гарсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах;

41.6.2.согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах, архины хэрэглээ, түүнээс үүссэн сөрөг үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих үйл ажиллагааг дэмжих;

41.6.3.архины хор хөнөөл, хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгэмд учрах хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх болон архины зохистой, соёлтой хэрэглээг олон нийтэд төлөвшүүлэх;

41.6.4.архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх;

41.6.5.архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг дэмжих;

41.6.6.согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих.

42 дугаар зүйл.Спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих

42.1.Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журмыг хүнсний, хууль зүйн, санхүү, эдийн засгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ Бусад

43 дугаар зүйл. Үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ, хэрэглээнд тавих хяналт

43.1.Согтууруулах ундааны үйлдвэрлэлд тавих хяналтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон мэргэжлийн хяналтын байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар хэрэгжүүлнэ.

43.2.Согтууруулах ундааны импортод тавих хяналтыг гаалийн байгууллага болон хилийн эрүүл ахуйн хяналтын алба хэрэгжүүлнэ.

43.3.Согтууруулах ундаа худалдах, хэрэглэх, түүгээр үйлчлэх талаар тогтоосон журмын биелэлтэд дараахь байгууллага, албан тушаалтан энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаар олгосон эрх хэмжээний дотор хяналт тавина:

43.3.1.бүх шатны Засаг дарга;

43.3.2.цагдаагийн байгууллага;

43.3.3.аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага;

43.3.4.эрх бүхий мэргэжлийн хяналтын байгууллага;

43.3.5.хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага.

43.4.Согтууруулах ундааны үйлдвэрлэлт, борлуулалт, импортод хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтан нэн даруй биелүүлэх үүрэгтэй.

44 дүгээр зүйл. Зөрчлийн талаар мэдээлэл авах

44.1.Согтууруулах ундаа хууль бусаар үйлдвэрлэсэн, улсын хилээр нэвтрүүлсэн, борлуулсан зөрчлийн талаар мэдээллийг төрийн эрх бүхий байгууллага иргэнээс төлбөртэй авч болно. Иргэнээс төлбөртэй мэдээлэл авахад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль¹-ийн 14 дүгээр зүйлийг баримтална.

45 дугаар зүйл.Татвар, хураамж төлөх, онцгой албан татварын тэмдэг

45.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд хууль тогтоомжид заасны дагуу татвар, хураамж төлнө.

45.2.Экспортлохоос бусад Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн болон импортлосон согтууруулах ундаа нь онцгой албан татварын тэмдэгтэй байх бөгөөд онцгой албан татварын тэмдэггүй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.

45.3.Энэ хуулийн 45.2-т заасан нь гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан согтууруулах ундаанд хамаарахгүй.

46 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

46.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

46.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг